

ЗУРАГ ТӨСЛИЙН АЖИЛ БОЛОВСРУУЛАХ ГЭРЭЭ

20 ... оны ... дугаар
сарын ...-ний өдөр

№

Улаанбаатар хот

НЭГ. ГЭРЭЭНИЙ ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ

- 1.1. Зураг төсөл боловсруулах талаар захиалагч гүйцэтгэгчийн хоорондын гэрээ /цаашид “гэрээ” гэх/-г Нэг талаас “.....” ХХК, цаашид “Захиалагч” гэх)-ийг төлөөлж гүйцэтгэх захирал, Нөгөө талаас: “.....” ХХК регистрийн дугаар, цаашид “Гүйцэтгэгч” гэх)-г төлөөлж гүйцэтгэх захирал /цаашид хамтад нь талууд гэх/ нар нь Монгол Улсын Иргэний хууль, Барилгын хууль болон бусад холбогдох хууль тогтоомж, өгөгдсөн зургийн даалгавар, ДБХ-ийн сайдын 2012 оны 06-р сарын 13-ны өдрийн 182 тоот тушаалаар батлагдсан “Зураг төслийн ажлын жишиг үнэ”-д үндэслэн, харилцан тохиролцсоны үндсэн дээр байгуулав.
- 1.2. Гүйцэтгэгч нь Захиалагчийн захиалгыг үндэслэн баригдах барилгын эскиз зураг, ерөнхий төлөвлөгөө, барилга архитектур, барилга бүтээцийн хэсгийн зураг төслийн иж бүрдэл ажлыг гүйцэтгэхтэй холбогдсон захиалагч, гүйцэтгэгчийн хооронд үүсэх харилцааг зохицуулахад энэхүү гэрээний зорилго оршино.
- 1.3. Энэхүү гэрээ нь зураг төсөл боловсруулах ажлын үнэ, чанар, гүйцэтгэх хугацааг эцэслэн тохирох үндэслэл болно.
- 1.4. Зураг төсөл боловсруулах техникийн даалгаварыг энэхүү гэрээнд хавсаргана. Энэхүү хавсралт нь гэрээний салшгүй хэсэг болно.
- 1.5. Дээрх зураг төсөл боловсруулах хугацаанд экспертизээр зураг батлуулах хугацаа орсон болно.
- 1.6. Гүйцэтгэгч нь гэрээт ажлыг 20 ... оны ... дугаар сарын ... -ны өдрөөс эхлэн 20... оны ... дүгээр сарын ...-ний өдөр хүртэл хугацаанд бүрэн гүйцэтгэж магадлал хийлгэн захиалагч талд актаар хүлээлгэн өгнө.

ХОЁР. ЗАХИАЛАГЧИЙН ЭРХ, ҮҮРЭГ

- 2.1. Зураг төсөл зохиоход шаардлагатайгар схем зураг, хайлах цехийн зураг төсөл боловсруулах техникийн даалгавар, геологи хайгуулын ажлын дүгнэлт, өндөржилт, зай хэмжээний зургийг файлаар нь гүйцэтгэгчид өгнө.
- 2.2. Зураг төсөл зохиох явцад өөрсдийн саналаар нэмэлт өөрчлөлт оруулах буюу гэрээний хугацааг өөрчлөх, гэрээг цуцлах шаардлага гарвал гүйцэтгэгчтэй хамтран гэрээг дүгнэж гүйцэтгэсэн ажлын хэмжээнд санхүүжүүлэх асуудлаа, эцэслэн шийдвэрлэнэ.
- 2.3. Захиалагч нь гүйцэтгэгчийн гүйцэтгэлд хяналт тавьж ажиллах бөгөөд гүйцэтгэгчийн буруутай үйл ажиллагаанаас гэрээт ажил хийгдэхгүй болсон тохиолдолд гэрээг нэг талын санаачлагаар цуцлаж гэрээний үнийн дүгийн 10%-тай тэнцэх хэмжээний торгууль төлүүлэх эрхтэй.
- 2.4. Бэлэн болсон экспертизээр батлагдсан зураг төслөө актаар 2 хувь хүлээж авна.

ГУРАВ. ГҮЙЦЭТГЭГЧИЙН ЭРХ, ҮҮРЭГ

- 3.1. Техник эдийн засгийн үндэслэлийн зураг төсөл боловсруулах техникийн даалгаврын дагуу зураг төслийн ажлыг гэрээнд заасан хугацаанд чанартай хийж гүйцэтгэх үүрэгтэй. Гүйцэтгэгч нь энэхүү гэрээний дагуу дараах ажил үүргийг гүйцэтгэх үүрэгтэй. Үүнд:

Үргэлжлэл бий